

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР

2019 ОНЫ АРВАННЭГДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 11 дүгээр сарын 26

Дорнод аймаг

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, А/75 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам” болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн 2019 оны 10 дугаар сарын 26-ний өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 25-ний өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд ОХУ-ын гарцтай Ульхан, Эрээнцав, БНХАУ-ын гарцтай авто замын Хавирга, Баянхошуу, Сүмбэр, Бичигт боомтууд хэлэлцээр ёсоор хуваарийн дагуу ажиллалаа. Тус хугацаанд Бүсийн газрын дарга Б.Тамир, мэргэжилтэн Г.Намуунзаяа нар 2019 оны ээлжийн амралтаа эдэлж дуусаад ажилдаа орсон. Байгууллагын даргын шийдвэрээр нэг албан хаагч ажлын 7 хоногийн чөлөө авч, шинээр 1 мэргэжилтэн томилогдож, 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Нэг. Захиргаа, удирдлага

Байгууллагын даргын 2019 оны “С.Баясгаланд чөлөө олгох тухай” Б/273, “Д.Оюунсүхийг мэргэжилтнээр томилох тухай” Б/280, “Б.Одмаад сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/284, “Д.Мөнхбаярт сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/285, “Зарим албан хаагчдыг танилцуулах айлчлалд хамруулах тухай” А/390, дугаар тушаал тус тус хүлээн авч хэрэгжүүлсэн.

Зүүн бүс дэх газар нь өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, албан хаагч нарын нийгмийн баталгааг хангах үүднээс Зүүн бүс дэх газрын даргын Б/14 дугаар “Б.Бадамринчинд мөнгөн тусламж олгох тухай” Б/15 дугаар “Төрийн үйлчилгээний албан хаагчдад арван нэгдүгээр сард ур чадварын нэмэгдэл олгох тухай” тушаалыг тус батлан хэрэгжүүлэн ажилласан.

Байгууллагын дарга, удирдлагуудаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах санал, хөдөлмөрийн дотоод журамд оруулах саналыг захиргаа удирдлагын газрын болон эрх зүй гадаад харилцааны хэлтсийн холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

Мөн хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст бүсийн газрын 10 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, байгууллагын даргын 2017, 2018, 2019 оны албан даалгавруудын биелэлт, 11 дүгээр сард хийх ажлын төлөвлөгөө, Ерөнхий сайдын айлчлалын талаар 01-12/128 дугаар бүхий илтгэх хуудас зэргийг тус тус хүргүүлсэн.

Уулзалт, зөвлөгөөн, хамтын ажиллагаа. Монгол улсын Ерөнхий Сайдын Дорнод аймагт ажиллах үеэрээ 11 дүгээр сарын 08-ны өдөр байгууллагын удирдлагуудтай уулзсан. Энэхүү уулзалтын арга хэмжээнд бүсийн газрын дарга Б.Тамир оролцсон.

Даваа гараг бүрийн өглөө 8 цагт зохион байгуулагддаг Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд дарга, ахлах мэргэжилтэн нар сууж орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг авч ажиллаж байна.

Захиргааны ахлах мэргэжилтэн С.Мөнхжаргал байгууллагын даргын баталсан тушаалын дагуу БНХАУ-н ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах газрын урилгаар 11 дүгээр сарын 18-с 22-ний өдрүүдэд БНХАУ-н Хөх хот, Ордос, Эрээн хотын товчооны үйл ажиллагаатай танилцаж харилцан мэдээ, мэдээлэл, туршлага солилцсон.

Сургалтад хамрагдсан талаар: Бүсийн газрын дарга Б.Тамир Удирдлагын академ дээр зохион байгуулагдсан Эрхэлсэн түшмэлийн 4 өдрийн сургалтад 11 дүгээр сарын 4-өөс 7-ний хооронд хамрагдаж гэрчилгээ авсан.

Байгууллагын даргын тушаалаар Сүхбаатар аймаг дахь ахлах мэргэжилтэн Ц.Солонго 11 дүгээр сарын 01-с 21-ний өдрүүдэд БНХАУ-н Шэньян хотод зохион байгуулагдсан “Хилээр орж гарах баримт бичгийн хяналт шалгалт” Олон Улсын сургалт зөвлөгөөнд оролцсон.

Мөн 11 дүгээр сарын 7-ны өдөр АНУ-н Монгол дахь Элчин Сайдын Яамнаас зохион байгуулсан “Баримт бичгийн хуурмаглал” сэдэвт 4 цагийн сургалтад ахлах мэргэжилтэн С.Мөнхжаргал, мэргэжилтэн Б.Одмаа, Д.Оюунчимэг нар хамрагдсан.

Нийгмийн баталгааг хангах талаар: ОХУ-тай хил залгаа Олон Улсын авто болон төмөр замын Эрээнцав боомт дахь албан хаагчдын амралтын байрны дотоод засварын ажлыг дуусгасан.

Сүлжээний инженер Б.Бадамринчин нь хүүхэд төрүүлсэн тул байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу тушаал гаргаж 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн.

Бичиг хэргийн эргэлтийн талаар: Ирсэн бичиг: Байгууллагын удирдлагаас 4, бусад байгууллагаас нийт 7 нийт 11-н албан бичиг ирж, үүнээс хариутай 8 албан бичгийг хүлээн авч 7 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.

Явсан бичиг: Ажлын зохион байгуулалттай холбоотойгоор байгууллагын удирдах албан тушаалтанд 4 албан бичиг, бусад байгууллагад 7 албан бичиг нийт 11 албан бичиг үйлдэж холбогдох байгууллагуудад явуулж мэдээ мэдээлэл солилцон ажилласан байна.

Өргөдөл: Тус сард албан хаагчдаас хувийн чөлөө хүссэн 2 өргөдөл хүсэлт хүлээн авч тухай бүр шийдвэрлэсэн.

Санхүүгийн талаар: 2019 оны 11 дүгээр сард 34,621,400 төгрөгийн санхүүжилтийг авснаас 32,761,587.31 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.

2019 оны 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн 444,158,100.00 төгрөгийн санхүүжилт, 395,246,196.63 төгрөгийн гүйцэтгэлтэй, 48,911,903.37 төгрөгийн үлдэгдэлтэй гарсныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хангалт, үйлчилгээний газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 10 дугаар сарын тайлангаар хүү, торгуулийн орлогод 3,473,000.00 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж орлогод 380,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Цалин хөлсний нийгмийн даатгалын 10 дугаар сарын тайлангаар нь нийт 27 албан хаагчдын 28,950,535.42 цалин, ногдол 6,765,389.55 төгрөг гарсныг нийгмийн даатгалын санд шилжүүлж, цахимаар шивж цаасаар баталгаажуулсан.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж шинэчлэгдсэн сайтад 2019 оны 10 дугаар сарын мэдээллийг хуулийн хугацаанд шивж дуусгасан.

Сар бүр санхүүгийн ил тод байдлын самбарын мэдээллийг шинэчлэн албан хаагчдыг санхүүгийн мэдээллээр ханган ажиллаж байна.

Эд, хөрөнгө, хангалтын талаар: Газрын үйл ажиллагааны урсгал зардал, төлбөрийг 09 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон харилцагч байгууллага болох “Дорнод Нийтийн Аж Ахуй” ХХК, “ДБЭХС” ТӨХК, “Цахилгаан холбоо” ХК, “Монгол шуудан” ХК, “НИК” ХХК, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-тай тооцоо нийлүүлсэн. Мөн автомашины зам/км, шатахуун, бараа материалын тооцоог тайлагнасан.

Бүсийн газрын “Техникийн комисс”-ын 06 дугаар хурлаар бүсийн төвд ашиглаж байгаа 75-55ДОА улсын дугаартай “Ниссан Патрол” автомашины эвдрэлийн талаар хуралдаж автомашиныг “Авто стандарт” засварын газарт дахин оношлуулахаар болсон.

Бүсийн 27-н албан хаагчид ханцуйтай болон богино ханцуйтай хар цамц, шинээр томилогдсон мэргэжилтэн Д.Оюунсүхэд өвлийн өмд, куртик, ёслол албаны хүрэм, ёслолын болон ноосон малгай, зангиа, тэлээ, хавар намрын гутал, хээрийн хувцас зэргээр хангасан. Бүсийн төв байрны тохижилт, үйлчилгээний чиглэлээр 41000 төгрөгийн 2 нэр төрлийн 2 ширхэг бараа материалыг худалдан авч холбогдох албан тушаалтанд шаардах хуудасны дагуу олгосон.

Эрээнцав боомтын амьдрах байранд хийгдэж байгаа урсгал засварт 14 нэр төрлийн 36 ширхэг 162,089 төгрөгийн үнэ бүхий барилгын материал нэмж худалдан авалт хийж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн.

Мэдээлэл, технологийн чиглэлээр: 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд хяналт тавьж ажилласан. Тус хугацаанд Бичигт, Хавирга боомтын дотоод сүлжээ тасалдахад шуурхай арга хэмжээ авч засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Хилийн боомтод хуваарийн дагуу ажиллаж байгаа хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрдэнэтуяа, мэргэжилтэн Б.Одмаа, Д.Оюунсүх нарын “ISM” системийн шилжүүлэх эрхийг бүртгэн авч, мэдээллийн технологийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн. Шинээр томилогдсон мэргэжилтэн Д.Оюунсүхэд ISM болон спарк програмын хэрэглэгчийн нэр, эрх нээж өгсөн.

Хилийн боомтуудын дотоод сүлжээнд ашиглагдаж байгаа 10 ширхэг компьютерт Eset endpoint security антивирусны програмын лицензийг сунгаж 11 дүгээр сарын антивирусны програмын шинэчлэлтийг хийж ажилласан.

Бүсийн газрын дотоод сүлжээ 11 дүгээр сарын 18, 19-ны өдрүүдэд тасалдахад “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК, мэдээллийн технологийн хэлтэстэй хамтран тасалдлыг илрүүлэн дотоод сүлжээг хэвийн ажиллагаанд оруулсан.

Төрийн албаны ил тод, нээлттэй байх, иргэдийг мэдээллээр хангах эрхийн дагуу www.immigration.gov.mn сайтын “Боомт орон нутаг” цэсэд 10 дугаар сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 11 дүгээр сарын төлөвлөгөөг шинэчлэн оруулсан.

Сүмбэр боомтын Дэлл Т1700 маркийн компьютерын эх хавтан эвдэрснийг оношилж, төхөөрөмжийн үнийн судалгааг дарга Б.Тамирт илтгэх хуудсаар танилцуулсан.

11 дүгээр сарын 3-ны өдрөөс 9-ны өдөр хүртэл Хэнтий аймаг, Сүхбаатар аймаг, Бичигт, Сүмбэр, Баянхошуу, Хавирга, Ульхан, Эрээнцав боомтуудад очиж бичлэг хийн бүсийн газрын танилцуулга видеоны зураг авалт хийсэн.

Монгол Улсад анх удаа ирсэн гадаадын 15 иргэний хурууны хээг “Transient card system” програмаар бүртгэн авч, мэдээллийн баазад оруулсан. Үүнд: Баянхошуу боомтод НГ ангиллын орох визээр орсон БНХАУ-ын 9 иргэн, бүсийн төвд 6 иргэн.

Хилийн боомтуудын хяналтын улсын байцаагч болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” систем болон компьютер техникийн 11 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.

Хоёр. Виз, зөвшөөрлийн чиглэлээр

Хариуцсан хилийн боомтуудаар нийт 5 орны / БНХАУ, ОХУ, Хонг Конг, Австрали, Франц / 4586 гадаадын иргэн улсын хилээр нэвтэрснээс орох чиглэлд 2107, гарах чиглэлд 2479 гадаадын иргэн нэвтэрсэн байна. Эдгээр иргэдээс БНХАУ-ын 42 иргэнд зохих ангилал, зориулалтын дагуу виз олгосон. Үүнд:

- “НГ” ангиллын визийг 29 иргэнд олгосон. Үүнээс:
 - “гарах-орох” нэг удаагийн зориулалттай виз -8;
 - Визийн шилжүүлэг- 21
- “Н” ангиллын визийг 3 иргэнд олгосон. Үүнээс:
 - Олон удаагийн “гарах-орох” зориулалттай виз -2;
 - Нэг удаагийн орох зориулалттай виз -1
- “S” ангиллын визийг 6 иргэнд олгосон. Үүнээс:
 - Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз -6
- “В” ангиллын визийг 3 иргэнд олгосон. Үүнээс:
 - Нэг удаагийн “орох” зориулалтын виз -3 / 04-19-6023 /
- “TS” ангиллын визийг 1 иргэнд олгосон. Үүнээс:
 - Нэг удаагийн “гарах-орох” зориулалттай виз 1 тус тус олгосон.

Хүчингүй болгосон виз: Бүсийн төвд “Чангже Саяан” ХХК-ны №35 тоот албан хүсэлтээр БНХАУ-ын 1 иргэний оршин суух зөвшөөрлийг цуцлан хасалт хийж, 3390753 тоот олон удаагийн гарах-орох зориулалтын визийг хүчингүй болгосон.

Алдаатай визийн бүртгэл: Нийт 6 Бичигт боомтод Эрээн хотод олгосон нэг удаагийн орох зориулалтын визэд байх хугацааг 91 хоногоор бичсэн тул бүртгэж хилээр оруулсан байна.

Түр ирэгчийн бүртгэл: Уригч иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтээр “S” ангиллын визтэй БНХАУ-ын 1 иргэн, Танзани Улсын 4 иргэн, зөрчил шийдвэрлэгдсэн

БНХАУ-ын 1 иргэн, “HG” ангиллын визтэй БНХАУ-ын 4 иргэн нийт 9 иргэнийг түр ирэгчийн бүртгэлд бүртгэж, зөрчил шийдвэрлэсэн БНХАУ-ын 1 иргэн, Танзани Улсын 4 иргэн нийт 5 иргэнд түр ирэгчийн хасалт хийсэн байна.

Оршин суух зөвшөөрлийн сунгалт: БНХАУ-ын 1 иргэний /GB-1/ оршин суух зөвшөөрлийн сунгалт хийх хүсэлтийг хүлээн авч төвд хүргүүлсэн.

Оршин суух зөвшөөрлийн хасалт: Аж ахуйн нэгжийн албан хүсэлтээр бүсийн төвд “HG” ангиллын ОСЗ-ийн хасалт 1, “Т” ангиллын ОСЗ-ийн хасалт 1 нийт 2 иргэний оршин суух зөвшөөрөлд хасалт хийсэн.

ХОНДЗҮ-ээр хил нэвтэрсэн БНХАУ-ын 72 иргэнийг бүртгэж, 68 иргэнд хасалт хийсэн.

Тайлант хугацаанд хувийн урилга олгогдоогүй.

Зөвлөгөө мэдээлэл: Хавирга боомтод БНХАУ-ын 16 иргэнд, Бичигт боомтод БНХАУ-ын 8 иргэнд, Баянхошуу боомтод БНХАУ-ын 2 иргэнд, бүсийн төвд 6 иргэнд виз, визийн ангилал, оршин суух, хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө өгсөн.

Ярилцлага хийсэн бүртгэл: Хилийн боомтуудад нийт БНХАУ-ын 40 иргэнтэй үүнээс Баянхошуу боомтод 1, Бичигт боомтод 17, Эрэнцав боомтод 2, Хавирга боомтод 20 иргэнтэй тус тус Монгол Улсад зорчих зорилготой нийцсэн эсэх талаар ярилцлага хийн тэмдэглэл хөтөлсөн.

Сүлжээний хяналт: ОХУ-д гарцтай Ульхан, Эрэнцав, БНХАУ-д гарцтай авто замын Хавирга, Баянхошуу, Бичигт боомтуудад хилээр зорчсон 5 орны 4586 иргэний хөдөлгөөнд хяналт тавьж, 2156 гадаадын иргэний мэдээллийг “ISM” сүлжээнд шалган нэвтрүүлсэн.

Газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн “Улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэдэд тавих хяналтыг сайжруулах тухай” 08 дугаар албан даалгаврын хүрээнд Баянхошуу боомтод 1 иргэн, Бичигт хилийн боомтод БНХАУ-ын 2 иргэн, Хавирга боомтод БНХАУ-ын 6 иргэн, Эрэнцав боомтод Казахстан Улсын 1 иргэнтэй тус тус ярилцлага хийн ГИЭЗБТХ-ын 22.1.6 дахь заалтыг үндэслэн нийт 10 иргэнийг хилээр оруулалгүй буцаасан.

Гурав. Хяналт шалгалтын чиглэлээр

Тайлангийн хугацаанд 12/05-201917, 12/05-201918 тоот удирдамжаар төлөвлөгөөт 2, Хэнтий аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дугаар тушаалаар баталсан удирдамжаар төлөвлөгөөт бус 1, иргэдээс ирсэн гомдол мэдээллийн дагуу 2 нийт 5 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар: Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газрын дарга, Дорнод аймаг дахь Цагдаагийн Газрын дарга нарын 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу 12/05-201917 тоот удирдамжийн хүрээнд Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт зочид буудлын зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй Ган-Хэрлэн, Ийст Паласе, Ольхон, Чадангууд, Болор, Рояаль, Түшиг, Чойбалсан, То-Ван, Билэг зэрэг зочид буудлуудад, 12/05-201918 тоот удирдамжийн хүрээнд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Бадмаараг хаш,

Андын элч ХХК-дад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтад 13 аж ахуй нэгжийн гадаадын 28 /БНХАУ-ын 27, Швед Улсын 1/ иргэн хамрагдсан. Илэрсэн зөрчилгүй.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 20 аж ахуй 166 иргэн хамрагдсан. Үүнээс: Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын 40/1857 албан бичгээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэний баримт бичгийг шилжүүлэн ирүүлсний дагуу хяналт шалгалтыг хийж гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тогтоол үйлдэж Прокурорын хяналтад оруулсан.

Дорнод аймгийн Тагнуулын газрын мэдээллийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 3 иргэнд холбогдох асуудлыг хүлээн авч, Монгол Улсад ирсэн зорилгыг тодорхойлж ярилцлага хийн тус 3 иргэнийг Монгол Улсад ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан гэж үзэх нотлох баримт хангалтгүй байсан тул шалгалтын ажиллагааг дуусгаж Хяналт шалгалтын газрын дарга Н.Баянмөнх-д илтгэх хуудсаар танилцуулж ажилласан.

Хэнтий аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналтад 19 аж, ахуй нэгжийн 162 гадаадын иргэн хамрагдсан. Шалгалтаар 6 аж ахуй нэгжид оршин суух зөвшөөрөл авсан аж ахуй нэгж, байгууллагадаа үйл ажиллагаа явуулаагүй зөрчлийг илрүүлж, хяналт шалгалтын газарт танилцуулж зөрчлийг шийдвэрлэж ажилласан.

Зөрчил шийдвэрлэсэн талаар: Бүсийн хэмжээнд 4 зөрчил илрүүлж хувь хүнээр 3 гадаадын иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 480000 төгрөгөөр /Дөрвөн зуун наян мянга/-н төгрөгөөр, уригчаар 1 аж ахуй нэгж байгууллагын 1 иргэнд 60000 /жаран мянга/-н төгрөгийн нийт 540000 /таван зуун дөчин мянга/-н төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн.

Хил дээрээс буцаагдсан иргэдийн талаар: Хавирга боомтод Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 6 иргэн /22.1.6 дахь заалтыг үндэслэн/, Бичигт боомт БНХАУ-ын 2 иргэн /ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалтыг үндэслэн/, Баянхошуу боомтод БНХАУ-ын 1 иргэн /ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалтыг үндэслэн/ Баянхошуу боомтод БНКазастан Улсын 1 иргэн нийт 1 иргэнийг орох чиглэлд хилээр нэвтрүүлэлгүй буцаасан.

Тайлангийн хугацаанд албадан гаргагдсан болон албан шаардлага хүргүүлсэн гадаадын иргэн байхгүй.

Байгууллагын даргын №04 албан даалгаврын хүрээнд:

Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан эрх зүйн хэлбэрийг зааврын дагуу үйлдэж зөрчил тус бүрд дугаарлалтыг өгч ажилласан.

Дорнод аймагт 4 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж харьяа Прокурорын газрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хяналтад оруулах ажиллагааг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

Бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн объектын судалгааг аж ахуй нэгж, оршин сууж буй хэлбэрээр тус бүр нарийвчлан гаргаж шинэчилсэн судалгааны ажлыг хийж дуусгаж, нэмэлт баяжилт хийж явж байна

Байгууллагын даргын 2019 оны 03 тоот албан даалгаврын хүрээнд:

1. Тайлангийн хугацаанд 4 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж нийт 540.000.0 /таван зуун дөчин мянга/-н төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулж, зөрчлийг шийдвэрлэсэн байна.

2. Хасалтын хугацаанд Монгол Улсаас гараагүй гадаадын иргэн байхгүй .

3. Бүсийн хэмжээнд нийт 1428 гадаадын иргэн албан болон хувийн хэргээр оршин сууж байгаагаас Дорнод аймагт 1095, Хэнтий аймагт 136, Сүхбаатар аймагт 197 иргэн амьдарч байна. Тайлангийн хугацаанд оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн гадаадын иргэн, аж ахуй нэгж байхгүй.

Байгууллагын даргын 2019 оны 08 тоот албан даалгаврын хүрээнд:

1. Тус сард Монгол Улсад байх хугацааны нийлбэр тухайн жилд 180 хоногоос илүү хэтэрсэн БНХАУ-ын 3 иргэнийг ярилцлага хийж тэмдэглэл хөтөлж хилээр нэвтрүүлэлгүй буцаасан.
2. Хяналт шалгалтаар оршин суух зөвшөөрөл авсан аж ахуй нэгж байгууллагадаа үйл ажиллагаа явуулаагүй 4 аж ахуй нэгж, БНХАУ-ын 43 иргэний талаар хяналт шалгалтын газарт танилцуулж, дээрх иргэд нь зөрчлөө арилгаж, хасалт хийлгэж Монгол Улсаас гарсан байна.
3. Цахим сүлжээнд Дорнод аймгийн Баян-түмэн сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт гадаадын иргэд өрөмдлөг хийж байна гэх мэдээллийн дагуу шалгалтыг явуулсан. Газар дээр нь шалгах явцад илэрсэн зөрчилгүй, малчдаас мэдээлэл авахад гадаадын иргэд манай нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан зүйл байхгүй гэж мэдүүлж байсан.
4. Бүртгэлээр хяналт тавих ажиллагааг өдөр бүр тавьж боомтод ажиллаж буй хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн нарт үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

ТАНИЛЦСАН.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ДОТООД АУДИТ, ОРОН
НУТГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАТСҮХ

ХЯНАСАН.

ЗҮҮН БҮС ДЭХ
ГАЗРЫН ДАРГА

Б.ТАМИР

ТАЙЛАН БИЧСЭН.

ЗАХИРГААНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.МӨНХЖАРГАЛ